

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД БӨГӨӨД ГАДААД
ХАРИЛЦААНЫ САЙД М.ЭНХСАЙХАНЫ НҮБ-ЫН ЕРӨНХИЙ
АССАМБЛЕЙН 51 ДҮГЭЭР ЧУУЛГАНД ХЭЛСЭН ҮГ**

/хэсэглэн авав/

... Монгол Улсын Засгийн газар олон тулгуурт гадаад бодлогынхоо залгамж шинж чанарыг хадгалахын зэрэгцээ идэвхтэй, тэнцвэртэй, үндэсний эрх ашигт нийцсэн байх зарчмын үндсэн дээр гадаад бодлогын үйл ажиллагаагаа явуулах болно.

Манай гадаад бодлогын үндсэн тулгуурын нэг болж ирсэн НҮБ-ын олон талт үйл ажиллагааг Монгол Улс цаашид ч бүрэн дэмжинэ.

Ноён дарга аа,

Хэдхэн өдрийн өмнө Цөмийн туршилтыг бүрмөсөн хориглох гэрээг Ерөнхий Ассамблей баталснаар олон улсын хамтын нийгэмлэг цөмийн зэвсэггүй дэлхий ертөнцөд хүрэх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн томоохон үйл явдлын гэрч боллоо. Надад Монгол Улсын нэрийн өмнөөс энэ Гэрээнд гарын үсэг зурах завшаан өнөө өглөө тохиолоо. Уг Гэрээг цөмийн зэвсэгтэй болон зэвсэг үйлдвэрлэх чадавхитай улс орнууд бүгдээр соёрхон батлах нь олон жилийн нөр их хөдөлмөрийг тодорхой үр дүнд хүргэхэд чухал ач холбогдолтой болно гэж бид үзэж байна. Энэхүү чухал Гэрээг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс Монгол Улс Гэрээний олон улсын хяналтын системд өргөн оролцох болно.

Дэлхийн янз бүрийн бүс нутагт цөмийн зэвсэггүй бүсүүд шинээр бий болж байгаа нь бүс нутгийн болон дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд тус дөхөм болно гэж бид үздэг бөгөөд Африк, Зүүн өмнөд Азийг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласныг талархан дэмжиж байна. Монгол Улс 1992 онд өөрийн дэвсгэр нутгийг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан. Манай энэ саналыг цөмийн зэвсэгтэй болон бусад улс орнууд дэмжсэнийг баяртайгаар тэмдэглэхийг хүсч байна. Монгол Улс энэхүү статусаа олон улсын төвшинд хүргэн баталгаажуулахаар ажиллах болно. Уг асуудалд өргөн утгаар хандвал цөмийн зэвсэггүй орнуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх, хэрэглэхээр заналхийлэхгүй байх баталгааг олон улсын тохиролцооны хэлбэрээр гаргах нь чухал ач холбогдолтой болох юм.

Цөмийн зэвсгийг хураах, тархалтыг хориглох асуудлаархи цаашдын яриа хэлэлцээнд цөмийн зэвсгийг хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэхийг эрх зүйн үндэслэлгүй гэж үзсэн Олон улсын шүүхийн зөвлөмж болон Канберрагийн комиссын мэдэгдэлд туссан чухал санаанууд тодорхой үндэслэл болж чадна гэж үзэж байна.

Химийн зэвсгийг хэрэглэх, үйлдвэрлэх, хадгалах, устгах тухай Конвенц хүчин төгөлдөр болоход ойртож байгаад сэтгэл ханамжтай байгаагаар илэрхийлэхийн хамт үйлдвэрлэх хөнөөх зэвсгийн нэг төрлийг устгах энэ Конвенцыг үр дүнтэй болгоход химийн зэвсгийн үлэмж нөөцтэй орнууд соёрхон батлахын чухлыг тэмдэглэмээр байна.

Ноён дарга аа,

Бүс нутгийн асуудлын хувьд Балкан, Солонгосын хойг болон бусад зарим бүс нутгийн тогтвортой бус байдал бидний сэтгэлийг түгшээсээр байна. Ялангуяа Ойрхи Дорнод дахь сүүлийн үеийн байдал энхийн үйл явцад сөрөг нөлөө үзүүлэх аюултай болж байна. Иймд холбогдох талууд асуудалд дээд зэргийн хүлээцтэй хандаж, түүнийг Мадрид, Ослогийн тохиролцооны дагуу улс төрийн яриа хэлэлцээ явуулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ноён дарга аа,

Ядуурал, гадаад өрийн дарамт, баян ба хоосны хоорондын технологи, эдийн засгийн улам өсөн нэмэгдэж байгаа ялгаа, өлсгөлөн, тэжээлийн дутагдал, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах үзэл, гэмт хэрэг, хар тамхи зэрэг асуудалд дэлхий ертөнц нэрвэгдэх аваас хүн төрөлхтөн хөгжин дэвжих, амар жимэр, амьдрах тухай ярих боломжгүй билээ. Хэн нэгнийг хохироох замаар өөрийн сайн сайхныг хангаж болохгүй гэдэг нь ойлгомжтой асуудал. Гэхдээ үүнийг зөвхөн ухамсарлаад зогсохгүй эдгээр асуудлыг шийдвэрлэхэд хамтран зүтгэх жинхэнэ улс төрийн зориг хэрэгтэй.

НҮБ-ын ивээл дор өнгөрсөн жилүүдэд зохиогдсон хүүхэд, байгаль орчин, хүний эрх, хүн ам, нийгмийн хөгжил ба хүн амын суурьшил зэрэг асуудлаархи олон улсын бага хурлууд хүн төрөлхтөний ахуй амьдралыг сайжруулах ирээдүйн шаардлагыг тодорхойлон дүгнэж, хамтарч нийтлэг үйл ажиллагаа явуулах стратеги боловсруулсан билээ. Олон улсын эдгээр хурлын шийдвэрийг бүрэн дүүрэн, нийтээр хэрэгжүүлэх, мөрөөр нь арга хэмжээ зохиох, үр дүнг нь дүгнэх зэргээр олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны энэ шинэ хүрээ манай чуулганаар хэлэлцэгдэж буй «Хөгжлийн хөтөлбөр»-т тусгалаа олох ёстой гэж Монгол Улс найдаж байна. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөтөлбөрүүдийн салбарт НҮБ-ын системийн төрөл бүрийн байгууллагууд болон Бреттон Вуудын байгууллагуудын бодлого, үйл ажиллагааг байнга уялдуулан зохицуулж байх нь нэн чухал билээ.

Олон улсын хамтын нийгэмлэг эдгээр хурлуудын шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс хүний тогтвортой хөгжлийг хангахад хэрэгцээтэй нөөц, бололцоог нэмэгдүүлэх улс төрийн жинхэнэ эрмэлзэл гаргах шаардлагатай байна. Дэлхий нийтийн цэргийн зардлыг багасган, хүний эн тэргүүний хэрэгцээг хангахад

шаардагдах санхүүгийг нэмэгдэл эх үүсвэрийг дайчлан гаргаж авч болох юм гэж бид үзэж байна. Үндэснийхээ нийт бүтээгдэхүүний 0,7 хувийг хөгжлийн тусламжид зориулахаа амласан боловч бүрэн биелүүлэхгүй байгаа хандивлагч орнууд бидний ирээдүй нэг бөгөөд нэгдмэл гэдгээс дохио авна гэж найдаж байна.

Ноён дарга аа,

Дэлхийн худалдааны байгууллага нь хөгжлийн янз бүрийн төвшинд байгаа улс орнуудын эрх ашгийг нийтлэг зорилгод нийцүүлэн зохицуулсан олон улсын худалдааны бодлого боловсруулах, тэдгээрт үйлчлэх нийтлэг хэм хэмжээг тогтоох олон талт чуулга болж байгааг бид талархан дэмжиж байна. Монгол Улс тус байгууллагад гишүүнээр элсэж байгаа нь дэлхийн худалдаа, эдийн засгийн интеграцчилалд илүү өргөн хамрагдах боломж олгож байна. Үүний зэрэгцээ эдийн засгийн хөгжлийн өндөр хурдац, улс төрийн харьцангуй тогтвортой байдал давамгайлж байгаа Ази, Номхон далайн бүс нутгийн интеграцчилалд оролцох, энд өөрийн орон зайгаа олж эзлэх талаар Монгол Улс идэвхтэй бодлого явуулах болно.

Газар нутгийн түгжигдмэл, алслагдмал байдалд оршдог далайд гарцгүй хөгжиж буй орнууд хөгжин дэвжих замдаа онцгой бэрхшээлтэй учирч байна. Энэ тааламжгүй байршил нь эдгээр орнууд дэлхийн эдийн засгийн глобализацийн үйл явцаас улам тасран хоцрох аюулыг буй болгож байна. Иймээс Ерөнхий Ассамблейн 50 дугаар чуулганаар сайшаасан «Дамжин өнгөрүүлэх тээврийн салбарт далайд гарцгүй, дамжин өнгөрүүлэгч хөгжиж буй орнууд болон донор бүлгийн хоорондын хамтын ажиллагааны чиглэл»-ийг хэрэгжүүлэх нь практик ач холбогдолтойг тэмдэглэмээр байна.

Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаа нь хөгжиж байгаа орнууд дэлхийн эдийн засгийн тогтолцоонд үр ашигтай нэгдэх үйл явцыг түргэтгэх боломжтой арга зам болж байна. Санхүү худалдаа болон хөрөнгө оруулалтын асуудлаар ирэх оны нэгдүгээр сард Коста Рикад болох бага хурал нь Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чухал хувь нэмэр болно гэж найдаж байна.

Ноён дарга аа,

Шинжлэх ухаан, техникийн хувьсгал улам эрчимжиж буй өнөө үед хүрээлэн буй орчныг хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөллөөс хамгаалах асуудлын ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байна. Ялангуяа байгалийн эмзэг бүсэд орших улс орнуудын хувьд ч аж үйлдвэржүүлэлтийн сөрөг үр дагаврыг урьдчилан тооцох, дахин давтагдашгүй байгаль орчныг нь хамгаалах, байгалийн гэнэтийн гай гамшгаас урьдчилан сэргийлэх учирсан хохирлыг арилгах чиглэлд олон улсын үр ашигтай хамтын ажиллагаа

өнөөдрийн шаардлага болж байгаа бөгөөд энэ чиглэлд үзүүлж буй тусламжийг нэмэгдүүлэх, ашиглалтын үр өгөөжийг нь дээшлүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй юм. Тогтвортой хөгжлийн номлолыг тодорхойлж өгсөн «Хотол дэлхийн тунхаг», «XXI зууны Хөтөлбөр»-ийн үзэл санаанд нийцүүлэн Монгол Улсын ирэх зууны тогтвортой хөгжлийн үндэсний стратегийг боловсруулж эхлээд байна. «XXI зууны Хөтөлбөр»-ийн хэрэгжилтийн асуудлаар 1997 онд болох Ерөнхий Ассамблейн тусгай чуулганд Монгол Улс онцгой ач холбогдол өгч байна. Сүүлийн жилүүдэд байгалийн сүйрэл гамшгийн тоо эрс өсч байгаа тухай Ерөнхий нарийн бичгийн даргын илтгэлд /АБИХ дурдсаныг анхааралдаа авч, тусгай чуулганд бэлтгэх ажлын хүрээнд үүний учир шалтгааныг тодруулах зорилгоор судалгаа хийж болох юм гэж үзнэ.

Ноён дарга аа,

Өнөө үед олон улсын хууль зүйн хэм хэмжээнүүдийг дээдлэн сахих үзэл хандлагыг бэхжүүлэх нь чухал болж байгаа бөгөөд энэ утгаараа Далайн ёроолын олон улсын байгууллага үүсэн байгуулагдсан болон Олон улсын эрүүгийн шүүхийг байгуулах явдлыг бид сайшаан дэмжиж байна.

Олон улсын хамтын нийгэмлэг хоёр талын болон олон талын дипломат үйл ажиллагааны үндсэн механизм болж чадахуйц олон улсын яриа хэлэлцээ явуулах үндсэн зарчмуудыг тодорхойлох нь оновчтой юм гэж бид бодож байна.

Ноён дарга аа,

Улс төрийн дээд хэмжээнд санал нэгтгэйгээр баталсан НҮБ-ын 50 жилийн ойн Тунхаглалын үзэл санааны дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагыг өөрчилж, үйл ажиллагааг нь ардчилж, үр ашгийг нь сайжруулах ёстой гэсэн бодол саналыг Монгол Улс бүрэн хуваалцаж байна. Ерөнхий Ассамблейн дээд хэмжээний ажлын хэсгүүд НҮБ-ын Дэлхийн улс орон, ард түмнүүдийн эрх ашигт илүү үр дүнтэй үйлчилж чадахаар, Дүрмэндээ заасан эрхэм зорилтуудыг хэрэгжүүлэх чадвартай, санхүүгийн чадавхитай бүтэцтэй болгох зөвлөмж гаргана гэж найдаж байна.

Үйл ажиллагааг нь ил тод болгох, ажлын арга барилыг нь ардчилах замаар Аюулгүйн Зөвлөлийн өөрчлөлт шинэчлэлийг идэвхжүүлэх шаардлагатай байна. Аюулгүйн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх нь бүс нутаг, бүлэг улсуудын төлөөллийг шударга, тэгш хангах, үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд үйлчлэх ёстой.

Дэлхий нийтийн энэ байгууллагын үйл ажиллагаа хэр амжилттай явагдах вэ гэдэг нь гишүүн улс орнууд бид бүхнээс хамаарах болно гэдгийг эцэст нь тэмдэглэе.

Ирэх зуун, шинэ мянган жил хүртэл дөрвөн жил хүрэхгүй хугацаа үлдлээ. Шийдвэртэй алхам хийж, хамтарсан өөрчлөлт

хэрэгжүүлэх, хойч үедээ сайн сайхан ирээдүй байгуулах өвөг дээдсийнхээ мөрөөдлийг биелүүлэхээр хамтран ажиллах цаг ирээд байна.

**Элчин харилцаа болбаас төрийн
алтан аргамж мөн.**

Эзэн богд Чингис хаан

МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ АЛБА ҮҮСЧ ХӨГЖСӨН ТҮҮХЭЭС
/1911-1961 он/

Р.Янжмаа*

ХҮI жарны цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 буюу 1911 оны 12 дугаар сарын 29-нөөр орчин үеийн . Монгол улсын дипломат албаны шинэ цаг тооллын хуанли эхэлдэг. Чухам энэ өдөр харийн дарлалд олон зууны туршид дарлагдан талхигдан байсан монгол түмэн эрх чөлөөгөө байлдан олж, туурга тусгаар улс гэрээ төвхнүүлэн байгуулж, төр, шашны тэргүүнээрээ Богд Жавзандамба хутагтыг өргөмжилсөн билээ.

Тэрвээр Монгол улсын хаан ширээнд өргөмжлөгдмөгц төр, засгаа эмхлэх ажилд орж, таван яам байгуулан, Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн захиран шийтгэх яамны тэргүүнээ чин ван Мижиддоржийн Ханддоржийг тохоон томилж, улс орноо чөлөөлөх үйлсэд оруулсан хүчин зүтгэлийг нь үнэлэн цол, чимгээр шагнажээ.

Чин ван Ханддорж унасан газар, угаасан усандаа туйлын хайртай, ард түмнээ чин зүрхнээс хайрладаг, голч холч бодлоготон байлаа. Тэрвээр аливаа нэгэн ажлыг мэдлэг боловсролтой, түвшин нуруутай хүмүүс бүтээдэг гэж үздэг учир орчин цагийн алтан аргамжийн цогцыг бүрдүүлэн шавыг тавихдаа мэдлэг боловсролтой хүмүүсийг бүх монгол туургатан: ар, өвөр, буриад, барга, уйгар, ордос, урианхай монголчууд дотроос хайн сурвалжилж, яамныхаа цөмийг бүрдүүлж эхэлжээ.

Гадаад хэргийг бүгд ерөнхийлөн захиран шийтгэх яам Түүнийг цаашид Гадаад хэргийн яам хэмээн товчлов үйл ажиллагаагаа нийт 42 орон тоотойгоор эхэлснээс 26 нь жинхэнэ дипломат албыг хашиж байв. Гадаад хэргийг шийтгэн явуулах үүрэг бүхий яамыг бүхэлд нь тэргүүн сайд, хоёр дэд сайд, нэг эрхэлсэн түшмэл, хоёр дэс түшмэлийн хамт удирдах бөгөөд өмнөд, умард, төв 3 хэлтэс нь чиг чиглэлийнхээ үүргийг хариуцдаг байжээ. Тухайлбал, Өмнөд хэлтэс (эх зохиогч түшмэл 2, жинхэнэ бичээч 4, хятад бичиг орчуулагч түшмэл 1, хятад үсгийн бичээч 1) Дундад иргэн улстай

* Гадаад харилцааны Яамны ажилтан.